

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



НИЙЦЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

“УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ”-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН
АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГНАГ-2025/06-02-ШТА-НА

Дундговь дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70592225

Цахим хаяг: Dundgovi@audit.gov.mn

Аудитор: О.Баярсайхан

Аудитор: Л.Уранбилэг

Аудитор: Г.Үүрийнтуяа

Утас: 7059-2208

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

“УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ”-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Огноо: 2025.04.21

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	ГНАГ-2025/06-02-ШТА-НА	Шалгагдсан байгууллага, нэгжийн	АЗДТГ, ХБТХОХ, ХААГ, ГХБХБГ, Төрийн байгууллагууд
Аудитын нэр:	“УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ”		
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан:	Гүйцэтгэл, нийцлийн аудитын баг

Хоёр. Аудитын үр дүн:

2.1 Аудитын зорилго, хамрах хүрээ:

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх;
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх.

Аудитыг Дундговь аймагт 2024 онд улс, орон төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хүрээнд үндэслэн хийсэн.

2.2 Бүлэг А. Аудитын дүн:

А. Гол асуулт / аудитын дэд зорилт 1: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?

Хариулт: Хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээг холбогдох журам, аргачлалын дагуу төлөвлөхгүй байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 148,561.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэх саналыг бэлтгэн төсвийн

хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем /pimis.publicinvestment.gov.mn/ -д оруулж, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Хүснэгт 1: 2024 онд хэрэгжүүлэхээр хүргүүлсэн төсөл, арга хэмжээний санал журмын шаардлага хангагдсан байдал

Салбар	Бодлогын баримт бичигт тусгагдсан эсэх		Зураг төсөвтэй эсэх			Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын шинжилгээтэй эсэх		
	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Шаардлагагүй	Тийм	Үгүй	Шаардлагагүй
Боловсрол	6		5	1		2	2	2
Дэд бүтэц	7		6	1		3	1	3
Соёл, спорт	5		5			2	2	1
Төрийн захиргаа	3		2		1	2		1
Хөдөө аж ахуй	1		1			1		
Эрүүл мэнд	2		2			1		1
Дүн	24	0	21	2	1	11	5	8

Эх сурвалж: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

Дээрх 24 төсөл, арга хэмжээ нь Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцсэн, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих төсөл, арга хэмжээг төлөвлөжээ.

Аймгийн төвийн “Түмний хорооллын гадна инженерийн шугам сүлжээний ажил”, “Дэлгэрцогт сумын сургуулийн барилгын ажил” буюу нийт төслийн 8.3 хувь нь 2 төсөл, арга хэмжээ зураг төсөвгүй, 5 төсөл, арга хэмжээ буюу нийт төслийн 20.8 хувь нь эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын шинжилгээ, үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардлын тооцоог хийгээгүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмын 3.2.1, 3.2.2¹ дэх заалттай нийцэхгүй байна.

Иймд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө нэгдсэн бодлого, хэрэгцээ шаардлагад үндэслэсэн эрэмбийг харгалзан эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын шинжилгээ, шинээр ашиглалтад орж байгаа үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо түүнийг санхүүжүүлэх эх үүсвэр, төсөвт нөлөөлөх ачааллыг тооцож, холбогдох журмын шалгуурыг хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 2: 2024 онд хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээний биелэлт

2024 оноос шинээр хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээ		ТАХ-ний тоо	Үүнээс	
			Хэрэгжсэн	Хэрэгжээгүй
Аймгийн засаг даргад эрх шилжиж ирсэн		7	2	5
Үүнээс	Аймгаас санал хүргүүлсэн	2	1	1
	Аймгаас санал хүргүүлээгүй	5	1	4

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

Хүснэгтээс харахад эрх шилжиж ирсэн 7 төсөл, арга хэмжээний 2 нь санал хүргүүлсэн 5 нь санал хүргүүлээгүй байна. Санал хүргүүлсэн 2 төсөл, арга хэмжээнээс Сайнцагаан сумын төрийн нэг цэгийн үйлчилгээний барилгын ажил гэрээний дагуу хийгдэж байгаа бол Өндөршил сумын соёл, урлагийн барилгын ажил гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулсан боловч зураг, төсөв хуучирсан тул төсвийг шинэчлүүлж магадлалаар батлуулан гэрээний дагуу үргэлжлэх боломжтой болсон байна.

¹ 3.2.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл нь Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна.

3.2.2.Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх дараах шаардлагыг хангаагүй төслийг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй;

Харин аймгаас санал хүргүүлээгүй 5 төсөл, арга хэмжээнээс 4 буюу 80 хувь нь магадлалын дүгнэлтээр хянагдсан төсөв нь батлагдсан төсөвт өртгөөс 2 дахин их, 3 удаа тендер зарлаад амжилтгүй болсон, зураг, төсөв худалдан авах ажиллагааны газар ирээгүйгээс тендер шалгаруулалт хугацаа алдаж, жилийн эцэст гэрээ байгуулсан зэрэг шалтгаанаар хэрэгжээгүй байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас хүргүүлсэн санал батлагдахгүй, журмын шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ батлагдаж байгаа нь худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд зохион байгуулж амжихгүй байх, улмаар батлагдсан санхүүжилт татагдах, гэрээний хугацаанд хэрэгжихгүй байх нөхцөл байдал үүсэж, ажил удаашрах шалтгаан болж байна.

2.3 Бүлэг Б. Аудитын дүн:

Б. Гол асуулт / аудитын дэд зорилт 2: Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?

Хариулт: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа тендер шалгаруулалтын журмыг хуулийн дагуу сонгож зохион байгуулсан байна.

Засгийн Газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар²-ыг баримтлан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер шалгаруулалтын аргыг сонгосон байна.

Тайлант онд нийт эрх шилжиж ирсэн 14 төсөл, арга хэмжээнээс 2 их засвар, 4 тоног төхөөрөмж, 8 барилга, байгууламжийн ажил байсан бөгөөд харьцуулалтын аргаар 5, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 9 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар худалдан авах ажиллагааг төлөвлөсөн байна. Үүнээс 12 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Дараах 2 ТАХ-ний худалдан авах ажиллагаанууд дараах шалтгааны улмаас хийгдээгүй байна.

Үүнд:

1. Тайлан онд эрх шилжин ирсэн 770.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Гурвансайхан сумын Ахмадын өргөөний барилгын ажил зураг, төсөвгүйгээс 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн магадлалын ерөнхий дүгнэлтээр хянагдаж төсвийн дүн 1,459.2 сая төгрөг болж, анх батлагдсан төсвөөс 689.2 сая төгрөгөөр нэмэгдсэнээс худалдан авах ажиллагааг зарлах боломжгүй болсон.
2. Төв халхын дуулалт жүжгийн театр барилгын ажлын эрх 2023 онд шилжиж ирсэн байна. Төсвийг шинэчлэн 10,543.7 сая төгрөг улсын төсөв тусгагдсанаас тайлант онд 2,671.7 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Шинэчилсэн зураг төсвийг 2024 оны 07 дугаар сарын 31-ны өдөр магадлалын ерөнхий дүгнэлтээр хянуулахад 33,406.9 сая төгрөг болж, батлагдсан төсөвт өртгөөс 22,863.2 сая төгрөгөөр нэмэгдэж хянагдсан тул худалдан авах ажиллагааг зарлаагүй байна.

Захиалагчаас батлагдсан төсөл, арга хэмжээний зураг төсөв, ТЭЗҮ-г худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхгүй удсанаас үнэлгээний хороо байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулах боломжгүй нөхцөл байдал үүсэж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад цаг хугацаа алдаж байна.

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.1-т төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, харьяалах төсвийн шууд захирагчид эсвэл аймаг, нийслэлийн Засаг даргад тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор шилжүүлж болно гэж заажээ. Гэвч тайлант онд эрх шилжиж ирсэн 14 ажлын 5 төсөл, арга хэмжээний эрх шилжүүлсэн шийдвэр дээрх хугацаанд багтаж гарсан бол 9 төсөл, арга хэмжээний эрх шилжүүлсэн шийдвэр 1 дүгээр сарын 20-ны өдрөөс хойш буюу 4 төсөл, арга хэмжээ нь журамд заасан хугацаанаас 10-25 хоногийн дараа, 5 төсөл, арга хэмжээ нь 35-91 хоногийн дараа эрх шилжүүлсэн шийдвэр нь гарчээ. Ингэснээр худалдан авах ажиллагаа эхлэх хугацаа хойшилж төслийн хэрэгжилт удааширч, төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэх боломжгүй болж байна.

² 1. Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар /Бараа-20.0, Ажил-20.0, Үйлчилгээ-20.0/

2. Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар /Бараа-100.0, Ажил-150.0, Үйлчилгээ-100.0/

Тендер зарлагдсан 12 төсөл, арга хэмжээний үнэлгээний хороог дараах байдлаар байгуулж, тендер зарласан байна. Үүнд:

- 5 ТАХ-г эрх шилжүүлэх шийдвэр ирснээс 11-27 хоног,
- 6 ТАХ-г эрх шилжүүлэх шийдвэр ирснээс 83-171 хоног,
- 1 ТАХ-г эрх шилжүүлэх шийдвэр ирснээс 256 өдрийн дараа байгуулсан байна.

Засаг даргад болон Ус, цаг уур, орчны шинжилгээний төвд эрх шилжиж ирсэн 10 тендерийн баримт бичгийг захиалагчаар батлуулсан боловч Эрүүл мэндийн газарт эрх шилжиж ирсэн 2 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг батлуулаагүйгээр худалдан авах ажиллагааг зарлажээ.

Тайланд онд нийт 12 төсөл, арга хэмжээнд 32 удаагийн тендер шалгаруулалт зарласан бөгөөд 10 арга хэмжээ буюу 83 хувь нь амжилттай болж гэрээ байгуулсан байна.

Амжилттай болсон 10 худалдан авах ажиллагааны 3 нь анхны тендер шалгаруулалтаар амжилттай болон гэрээ байгуулсан байна. Үүнд “Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж”-ийн тендерт 2 оролцогч, “Ахмадын хөгжлийн төвийн тоног төхөөрөмж”-ийн тендерт 5 оролцогч, Сайнцагаан сумын “Төрийн нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн барилгын тендерт 1 оролцогч тендер ирүүлэн гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулсан байна.

Бусад амжилттай болсон 7 төсөл, арга хэмжээнд нийт 23 удаагийн тендер зарлагдсан. Үүнээс 13 удаагийн тендер шалгаруулалт нь оролцогчгүй, 3 удаагийн тендер оролцогчдын ирүүлсэн санал нь шалгуур хангаагүй учир амжилтгүй болсон байна. Цагаандэлгэр сумын 240 суудалтай Соёлын төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилтын угсралтын ажлын 2 удаагийн тендер шалгаруулалт оролцогчгүй байснаар амжилтгүй болсон учир үнэлгээний хороо хуралдан тендер шалгаруулалтын баримт бичиг, шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт оруулан дахин зарлаж 2 оролцогч тендер ирүүлж тендер шалгаруулалт амжилттай болжээ.

Тайлант онд 2 төсөл, арга хэмжээг тус тус 3 удаагийн тендер шалгаруулалт зарласан боловч амжилтгүй болжээ. Үүнд:

1. Тайланд хугацаанд 1 төсөл, арга хэмжээ буюу Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" /Говьсүмбэр, Дундговь/ төсөл, арга хэмжээнд зарласан 3 удаагийн тендер шалгаруулалтад гомдол гарсан бөгөөд 2 нь Сангийн яаманд шаардлага хангаагүй оролцогчид гэрээ байгуулах эрх олгосон тухай, 1 нь Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт тендерийн явцад тусгай зөвшөөрөлтэй холбоотой хүргүүлсэн гомдол байна. Эдгээр нь гомдол гаргагчийн талд шийдвэрлэгдсэн бөгөөд тендерийн бичиг баримтад өөрчлөлт оруулан дахин зарлах, захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон 2 шийдвэрийг хүчингүй болгохоор шийдвэрлэгдсэн байна.
2. Өлзийт суманд хийгдэх Ногоон байгууламж бүхий орчны тохижилтын тендер шалгаруулалтыг анх нээхэд оролцогчгүй байсан учир дахин зарлан нээхэд 1 компани оролцсон боловч баримт бичиг нь шаардлага хангаагүй учир амжилтгүй болсон. Тайлант оны 12 дугаар сарын 03-ны өдөр гурав дахь удаа тендер зарлан 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр нээхээр төлөвлөж байсан ч улирлаас шалтгаалан ногоон байгууламжийн ажлын тендерийг өвөл зарлаж болохгүй гэсэн иргэний саналыг харгалзан үзэж Төрийн худалдан авах ажиллагааны газраас уг тендерийг хүчингүй болгосон байна.

Дээрх гомдол нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26³ дугаар зүйлд зааснаар хянаагүй байна.

Иймд тендер оролцогчдын ирүүлсэн тендерийг хянахдаа хуулийн дагуу тендерийн баримт бичигт заасан ерөнхий шаардлага, чадавхын болон туршлагын шаардлагыг хангаж байгаа эсэх, нотлох баримтыг бүрэн ирүүлсэн эсэх нягталж хянан үзэх, тендерийн баримт бичигт зохих өөрчлөлт оруулан аль болох богино хугацаанд, цаг алдахгүй тендер шалгаруулалтыг зохион байгуулах шаардлагатай байна.

2.4 Бүлэг В. Аудитын дүн:

В. Гол асуулт / аудитын дэд зорилт 3: Хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан уу?

³ 26 дугаар зүйл. Тендерийг хянан үзэх

Хариулт: Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй, бий болсон хөрөнгийг хууль, журмын дагуу санхүүжүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль, журмын дагуу санхүүжүүлсэн байна.

Өмнөх оноос шилжиж ирсэн 4,066.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 7 төсөл, арга хэмжээ, шинээр хэрэгжих 7,066.7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 13 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн 9 төсөл, арга хэмжээнд 2,740.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгож ажилласан байна.

Шинээр 2024-2025 онд гүйцэтгэж дуусах ажлуудаас Сайнцагаан сумын Төрийн нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга нь 3,873.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендер зарлагдаж “Жи Жи Ай” ХХК шалгарч 3,722.8 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээг байгуулж, ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна. Цагаандэлгэр сумын 240 хүний суудалтай Соёлын төвийн барилгын гадна шугам сүлжээний ажлын тендер 2024 онд зарлагдаж Мандал шилтгээн ХХК-тай 751.8 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээг байгуулж, 2024 онд ажил хийгээгүй тул санхүүжилт олгоогүй байна. Үндсэн барилгын ажил нь шугам сүлжээний ажил хийгдсэний дараа хийгдэхээр болж, ажлын явц 74 хувьтай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан Гурвансайхан сумын ахмадын өргөөний барилгын ажлын төсвийг магадлалын дүгнэлтээр 1,459.2 сая төгрөг болж 630.0 сая төгрөгөөр, Төв халхын дуулалт жүжгийн театрын ажлын төсвийг магадлалын дүгнэлтээр 33,406.9 сая төгрөг болж, 22,863.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн шалтгаанаар тендер зарлагдаагүй тул санхүүжилт татагдсан байна.

Мөн /Говьсүмбэр, Дундговь/ орон нутгийн хөгжлийг дэмжих 1,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Шинэ хөдөө" төсөл, арга хэмжээ, Өлзийт суманд хийгдэх 591.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ногоон байгууламж бүхий орчны тохижилт”-ын төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг тус бүр 3 удаа зарласан боловч тендер оролцсон компаниуд нь шаардлага хангаагүйгээс худалдан авах ажиллагаа амжилтгүй болж төсвийг буцаан төвлөрүүлсэн байна.

Холбогдох журмын шаардлага хангаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ батлагдсанаас ажил гэрээний хугацаандаа хэрэгжихгүй байна.

Дундговь аймгийн хэмжээнд 2024 онд нийт 9,738.8 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр эрх шилжиж ирснээс 9,538.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргад, 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээг аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв болон Эрүүл мэндийн газарт эрхийг шилжүүлсэн байна.

Ахмадын хөгжлийн төвд тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнээр ахмадуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, биеийн тамир, эрүүл хөдөлгөөн хийхэд таатай орчин бүрдсэн үр дүнтэй хөрөнгө оруулалт болсон хэдий ч зарим тоног төхөөрөмж чанаргүй нийлүүлэгдсэн байна.

Худалдан авах тоног төхөөрөмж, эд хогшлын техникийн тодорхойлолтод барааны үзүүлэлт, зах зээлийн үнэ ханшийг судалж бодитой тусгаагүйгээс чанаргүй тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна. Жишээлбэл: Хурлын индэр, буйдан, дартсын самбар, сум гэх мэт чанарын шаардлага хангахгүй тавилга, эд хогшил зах зээлийн үнээс хэт өндөр үнээр нийлүүлэгдэж, хүлээн авсан байна. Тоног төхөөрөмж хүлээн авах комисст нийлүүлэгдэж байгаа тоног төхөөрөмжийн талаар мэдлэгтэй албан хаагчийг томилох нь зүйтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12.1, 12.2-т заасан хуульд нийцэхгүй байна.

Иймд захиалагч төсвийн хөрөнгөөр бараа нийлүүлэгдэх төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахуйц, холбогдох стандарт, норм, дүрмийн дагуу боловсруулж, хүлээн авах комисст тухайн салбарын мэргэжлийн хүнийг оролцуулан томилох, гишүүдийн ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Он дамжсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашралтай хэвээр байна.

Он дамжин хэрэгжиж байгаа аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсэн 7 төсөл, арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 10: Он дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний мэдээлэл

Өмнөх оноос шилжсэн ТАХ-ний тоо	Хэрэгжиж эхэлсэн он			
	2011-2012	2013-2016	2017-2020	2021-2023
7	1	0	4	2

Эх сурвалж: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2011 оноос эхэлсэн “Төв халхын дуулалт жүжгийн театр”-ын барилгын ажил хамгийн их удаашралтай байгаа бол 2017-2020 онд эхэлсэн Цагаандэлгэр сумын “Соёлын төвийн барилга”, “Халуун ус, ахуй үйлчилгээний төвийн барилга”, Говь-Угтаал сумын “Спорт заалны барилга”, Эрдэнэдалай сумын “Хатуу хучилттай авто зам”-ын ажлууд хэрэгжиж дуусаагүй байна. Харин 2022 оноос хэрэгжиж эхэлсэн аймгийн төвийн “Гудамж талбайн тохижилт, ногоон байгууламж”, Хулд сумын “Ноос хяргах байгууламж, тоног төхөөрөмж”-ийн ажлууд 2024 онд комисс хүлээж авч, 349.6 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг олгосон байна.

Төв халхын дуулалт жүжгийн театрын барилгын ажлын хувьд анхны төсвийг 3,743.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 10,543.7 сая төгрөгөөр шинэчлэн хийлгэж, улсын төсвөөс 2023 онд 671.7 сая төгрөг, 2024 онд 2,671.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан боловч 2024.07.31-ны өдрийн магадлалын дүгнэлтээр зураг, төсөв 33,406.9 сая болж 22,863.2 сая нэмэгдэж, батлагдсан төсвөөр тендер зарлах боломжгүй тул тендерийг зарлагдаагүй байна. Уг төсөл, арга хэмжээ нь 2025 оны улсын төсөвт тусгагдаагүй, гацсан шийдэгдээгүй хэвээрээ байна.

Барилга угсралтын ажил нь зогссон болон удаашралтай төсөл, арга хэмжээг дуусгах талаар харьяа яамдтай хамтран үүссэн асуудлыг шийдвэрлэж, төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, ашиглалтад оруулахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Аймгийн Засаг дарга 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 12 барилга, байгууламжийн ажилд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраар захиалагчийн хяналт хийлгэхээр гэрээ байгуулж 3 төсөл, арга хэмжээнд хяналт хийсэн байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас гэрээний дагуу Сайнцагаан сумын “Төрийн нэг цэгийн үйлчилгээний барилга”, “Гудамж, талбайн тохижилт, ногоон байгууламж”, Хулд сумын “Ноос хяргах байгууламж, тоног төхөөрөмж”-ийн ажилд захиалагчийн хяналтыг хийж, тайлан, фото зургаар баримтжуулсан байна.

Захиалагчийн хяналтыг тайланд онд давхардсан тоогоор 7 удаа хийж, техник хяналтын зардалд 14.3 сая төгрөгийг зарцуулжээ.

Тендер амжилтгүй болж гэрээ байгуулаагүй 1, огт тендер зарлаагүй 2, гэрээ байгуулсан ч ажил эхлээгүй 2, он дамжсан удаашралтай ажил хийгдээгүй 4 нийт 9 барилга, байгууламжийн ажилд захиалагчийн хяналтыг хийгээгүй байна.

Хэрэгжиж дүүссэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу бүртгэлд тусгахгүй байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2022 оноос хэрэгжиж эхэлсэн 469.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй Хулд сумын “Ноос хяргах байгууламж, тоног төхөөрөмж”-ийн төсөл, арга хэмжээний ажил дуусаж аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2024.08.30-ны А/39 тоот тушаалаар томилогдсон комиссын 2024.09.09-ний өдрийн дүгнэлтээр, 888.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Гудамж талбайн тохижилт, ногоон байгууламж”-ийн ажлыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2024.06.24-ны А/23 тоот тушаалаар томилогдсон комиссын 2024.08.23-ны өдрийн дүгнэлтээр ашиглалтад оруулсан байна.

Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон дээрх хөрөнгүүдийг орон нутгийн өмчид бүртгээгүй байна. Хөрөнгийн эцсийн өмчлөгчийг тодорхойлж бүртгээгүйгээс хөрөнгө эзэнгүйдэх, эвдрэл гэмтэл үүсэх эрсдэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-

ын 5.5 дэх хэсгийн 5.5.1, 5.5.2, 5.5.3⁷-т заасан хөрөнгийг бүртгэхтэй холбоотой заалтуудыг хэрэгжүүлж ажиллахгүй байна. Иймд хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгүүдийг орон нутгийн өмчид бүртгэж, зөрчлийг арилгуулахаар албан шаардлагыг Орон нутгийн өмчийн газарт хүргүүллээ.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Үүнд:

1. Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө нэгдсэн бодлого, хэрэгцээ шаардлагад үндэслэсэн эрэмбийг харгалзан эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын шинжилгээ, шинээр ашиглалтад орж байгаа үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо түүнийг санхүүжүүлэх эх үүсвэр, төсөвт нөлөөлөх ачааллыг тооцож, холбогдох журмын шалгуурыг хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөөгүй байна;
2. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас хүргүүлсэн санал батлагдахгүй, журмын шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ батлагдаж байгаа нь худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд зохион байгуулж амжихгүй байх, улмаар батлагдсан санхүүжилт татагдах, гэрээний хугацаанд хэрэгжихгүй байх нөхцөл байдал үүсэж, ажил удааших шалтгаан болж байна;
3. Төсвийн ерөнхийлөн захирагчид төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрх шилжүүлэхдээ журамд заасан хугацааг баримтлаагүй байна;
4. Батлагдсан төсөл, арга хэмжээний зураг төсөв, ТЭЗҮ захиалагчаас худалдан авах ажиллагааны газарт ирэхгүй удсанаас үнэлгээний хороо байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулах боломжгүй нөхцөл байдал үүсэж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад цаг хугацаа алдаж байна;
5. Худалдан авах ажиллагаанд тендер шалгаруулалтын аргыг хуулийн дагуу сонгож, зохион байгуулсан байна;
6. Тайланд онд нийт 12 төсөл, арга хэмжээнд 32 удаагийн тендер шалгаруулалт зарласнаас 10 арга хэмжээ буюу 83 хувь нь амжилттай болж гэрээ байгуулсан байна;
7. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгож ажилласан байна;
8. Холбогдох журмын шаардлага хангаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ батлагдсанаас ажил гүйцэтгэх гэрээний хугацаандаа хэрэгжихгүй байна;
9. Он дамжсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашралтай хэвээр байна;
10. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу бүртгэлд тусгахгүй байна;
11. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт 62.5 хувьтай буюу төрийн аудитын байгууллагын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэхгүй байна;



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээг эрэмбэлэхдээ нийгэм, эдийн засгийн үр ашиг, шинээр ашиглалтад орж байгаа үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо түүнийг санхүүжүүлэх эх үүсвэр, төсөвт нөлөөлөх ачааллыг тооцож, холбогдох журмын шалгуурыг хангасан төсөл арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх;
2. Төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12⁹ дугаар зүйлд нийцүүлэн, холбогдох стандарт, норм, дүрмийн дагуу боловсруулж ажиллах;
3. Тоног төхөөрөмж, техник хэрэгслийг хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн албан хаагчийг түлхүү оролцуулж, техникийн тодорхойлолт, хүчин чадал, үзүүлэлтийг хангасан тоног төхөөрөмжийг хүлээн авах;

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сүм, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn 